

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 3.2.29 дэх зорилтын 3-т “Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах”-аар тусгагдсан. Энэ дагуу тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төсөл, дагалдах хуулийн төсөл, хэрэгцээ, шаардлагыг урьдчилсан судалгаа, үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог тус тус боловсрууллаа.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийг 1998 онд, тус хуулийн шинэчилсэн найруулгыг 2006 онд тус тус батлан мөрдүүлж, хэрэгжилтийг зохион байгуулан, шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны эрхзүйн харилцааг зохицуулж ирсэн. Дэлхийн улс орнуудын шинжлэх ухаан, технологийн хөгжлийн чиг хандлага, улс орны болон салбарын хөгжлийн бодлого, эрхзүйн шинэчлэлтэй уялдуулан энэхүү хуульд зарим нэмэлт, өөрчлөлтийг оруулах хэрэгцээ, шаардлага үүссэн.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагын урьдчилсан судалгааг гүйцэтгэсэн. Судалгаанд тусгагдсан санал, зөвлөмж, дүгнэлтийг үндэслэн Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тус салбарын бодлого тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх боломжтой гэж үзэж, уг хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсрууллаа.

Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг үзэл баримтлалын хүрээнд Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, төрийн ба төрийн бус байгууллага, улсын болон хувийн хэвшлийн эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулиудаас санал авч хуулийн төсөлд тусгасан. Мөн уг хуулийн төслийг улсын их хурлын цахим хуудсанд байршуулан олон нийтэд нээлттэй хэлэлцүүлж саналыг тусгасан.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд 6 хэсэг, 12 заалт нэмж, 5 хэсэг, заалтад нэмэлт оруулан, 9 хэсэг, 13 заалтыг өөрчлөн найруулж, 43 заалтад өөрчлөлт оруулан, 5 хэсэг, заалтыг хүчингүй болгон, 1 зүйлийн нэрийг өөрчилсөн бөгөөд 32 хэсэг, заалтад зөвхөн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажилтай холбогдсон нэр томьёог “судалгаа боловсруулалтын ажил” гэж өөрчлөн томьёолсноор тус хуулийн 39.4%-д нь нэмэлт, өөрчлөлт орохоор байна.

Ингэснээр тус хуулийн төсөлд зарчмын чанартай дараах нэмэлт, өөрчлөлтүүд тусгагдсан. Үүнд:

Хуулийн төслийн нэгдүгээр бүлэгт, “судалгаа боловсруулалтын ажил”, “суурь санхүүжилт” гэсэн нэр томъёоллыг шинээр тодорхойлж, хуулийн төслийн холбогдох заалтуудад тусгалаа.

Хоёрдугаар бүлэгт, Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн бүрэн эрхэд хамаарах 6.1.4, 7.2.4-7.2.8, 7.2.10-7.2.15, 8.1.11 дах заалтуудыг агуулгын хувьд бусад заалттай давхацсан, шаардлагагүй гэж үзэж, хүчингүй болгуулахаар хуулийн төсөлд тусгасан.

Захиргааны ерөнхий хуультай уялдуулан салбарын үйл ажиллагаатай холбоотой зарим эрхзүйн баримт бичгийг батлан хэрэгжүүлэх чиг үүргийг Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд тусгалаа.

Гуравдугаар бүлэгт, Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардлыг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын төсөвт тусган санхүүжүүлэх, үндсэн чиг үүргийн дагуух олсон орлогыг арилжааны банкны дансанд байршуулах захиран зарцуулах гэх мэт нэмэлтээр найруулан орууллаа.

Дөрөвдүгээр бүлэгт, шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны санхүүжилтийн зарчмыг шинэчилж, судалгаа хөгжүүлэлтийн ажлыг санхүүжүүлэх журмыг тогтоож өглөө. Судалгаа хөгжүүлэлтийн ажлыг Засгийн газрын баталсан журмын дагуу дараах хэлбэрээр санхүүжүүлэхээр тусгалаа. Үүнд:

- 1) Эрдэм шинжилгээний байгууллагад судалгааны үндсэн чиглэлээ хэрэгжүүлэхэд нь улсын төсвөөс санхүүжилт олгох,
- 2) Шинжлэх ухаан, технологийн төсөл сонгон шалгаруулж санхүүжүүлэх.

Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны үр дүнг тайлагнах заалтыг шинээр нэмлээ.

Тавдугаар бүлэгт, эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийг тогтоох зорилгоор магадлан итгэмжлэл явуулж байх, хүндэтгэн үзэх шалтгаанаар ээлжит магадлан итгэмжлэлд хугацаандаа хамрагдаж чадаагүй эрдэм шинжилгээний ажилтныг нөхөн хамруулж байх зохицуулалтыг тусгасан. Энэхүү заалт батлагдан хэрэгжсэнээр магадлан итгэмжлэлийн үндсэн агуулга өөрчлөгдөх бөгөөд тухайн хугацаанд хийж бүтээсэн ажил, ур чадвараа үнэлүүлэх, түүндээ тохирсон зэрэг дэвийн нэмэгдлийг хүртэх боломж бүрдэнэ. Ээлжит магадлан итгэмжлэлд хүндэтгэн үзэх шалтгаанаар хоцорсон, зэрэг дэвийн нэмэгдлээ авч чадахгүй байгаа эрдэм шинжилгээний ажилтнуудын асуудал нэг мөр шийдэгдэнэ.

Хуулийн төслийн 21.1.3-д энэ хуулийн 11.2-т заасан байгууллагад 25 ба түүнээс дээш жил судалгаа боловсруулалтын ажил эрхэлсэн эрдэм шинжилгээний болон

инженер-техникийн ажилтан, лаборант өндөр насны тэтгэвэр тогтоолгох бол ажиллаж байгаа байгууллагаас нь 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох;"-оор тусгаж өгсөн. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл санаатай бүрэн нийцэж байгаа бөгөөд оюуны хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, тус салбарт ажиллагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чухал алхам болно.

Зургадугаар бүлэгт, Хуулийн 22.1.1 дэх заалтад тусгагдсан шагналын тодорхойлолтыг “судалгаа боловсруулалтын ажил эрхэлж байгаль, нийгмийн шинэ үзэгдэл, зүй тогтол, хуулийг тодорхойлж, шилдэг бүтээл туурвисан иргэн, судлаачдын хамтлагт “байгаль, нийгмийн ухааны шагнал”;" гэж өөрчлөн найруулсан.

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдон санхүүгийн нэмэлт ачаалал улсын төсөвт үүсэхгүй. Тус салбарт хуваарилагдаж байгаа одоогийн төсвийн санхүүжилт, төсвийн бус орлогын хүрээнд зохицуулалт хийх замаар асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.

ХУУЛЬ САНААЧЛАГЧИД